



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/395

Номгон

Эмнэлгийн лабораторийн биохимийн
анализатор хүлээж авах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан Аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний 1.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн лабораторид Биохимийн анализаторыг нийлүүлэгчээс хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: В.Наранчимэг - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ичинхорлоо - Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

М.Дүгэрмаа - Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

Т.Хажидсүрэн- Эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга

Ө.Заяа- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Г.Баатартогтох - Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Лабораторийн тоног төхөөрөмжийг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн дотор хүлээн авч байгууллагын өмчид бүртгэж авахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Ц.Идэрмөнх)-т хариуцуулсугай.

3.Лабораторийн анализаторуудыг техникийн тодорхойлолттой тулган хүлээн авч, ажлын тайланг 07 дугаар сарын 31-ний дотор танилцуулахыг ажлын хэсэг (В.Наранчимэг)-т, Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдах биохимийн анализаторын ашиглалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН